



Хувь Нийлүүлэгчдийн ээлжит хурлын тэмдэглэл

2010.04.29

Тавантолгой.

Хурал 2010 оны 04-р сарын 29-ны өдөр Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Тавантолгой ХК-ийн хурлын танхимд 14 цаг 00 минутанд эхлэн хуралдав.

Хурлын ирц хувьцаа эзэмшигчдийн тоогоор нийт 518778 ширхэг, 98.5%-тай байна.

Ч.Тармандах /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/ - Хурлын дарга тэргүүлэгчдийг сонгох санал авъя.

Н.Ганхуяг: Санал байна. Хурлын тэргүүлэгчээр Б.Цэрэнпагма, Г.Цог-Өрнөх, Д.Бат-Эрдэнэ нарыг санал болгож байна. Санал хураахад хуралд оролцогсдын 100%-ийн саналаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар Г.Цог-Өрнөхийг, тэргүүлэгчдээр Б.Цэрэнпагма, Д.Бат-Эрдэнэ нарыг сонголоо.

Г.Цог-Өрнөх /Хурлын дарга/ - Хуралд хүрэлцэн ирсэн нийт хувьцаа эзэмшигчдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Хурлын дэг, хэлэлцэх асуудлыг батлая. /Хурлын дэг хэлэлцэх асуудлыг танилцуулав./

- Ирц гаргаж мэдээлэх /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/
- Хурлын дарга, тэргүүлэгчдийг сонгох
- Хурлаар хэлэлцэх асуудал болон хурлын дэгийг батлах /Хурлын дарга/
- ТУЗ-ийн ажлын тайланг танилцуулах. /ТУЗ-ийн дарга Д.Бат-Эрдэнэ -7 мин/
- ХШЗӨвлөлийн ажлын тайланг танилцуулах. /ХШЗ-ийн дарга - 5 мин/
- Гүйцэтгэх захирлын ажлын тайлан. /Гүйцэтгэх захирал Х.Түмэнбаяр - 5 мин/
- Компанийн 2009 оны санхүүгийн тайлан. /Ерөнхий ня-бо Г.Шүрэнхишиг - 5 мин/
- Асуулт-1мин, хариулт-3 мин
- Санал, шүүмжлэл, хүн бүрт-5мин, хурлыг 1 цаг тутамд завсарлана.
- Завсарлага
- Тавантолгой ХК-ийн хэтийн старатеги төлөвлөгөөний тухай
- 2009 оны жилийн эцсийн ногдол ашиг хуваарилах тухай
- ТУЗ-ийн болон ХШЗ-ийн төсөв танилцуулах /Эдийн засагч Ч.Төрмандах-4 мин/
- Бусад асуудал- “Тавантолгой ХК-ийн ҮЭХорооны тогтоол”-танилцуулах /Эдийн засагч Ч.Төрмандах-5 мин/
- Завсарлага
- Тооллогын комиссыг сонгох /Хурлын дарга/
- Тооллогын комиссын тогтоол сонсгох /Тооллогын комиссын дарга/
- Хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулах, батлах /Хурлын дарга/